



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 08 өдөр

Дугаар A/29

Улаанбаатар хот

Г 7

Болзолт уралдаан зарлах тухай

Эрүүл ахуйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

- “Шилдэг ариун цэврийн байгууламж” болзолт уралдааныг салбарын эрүүл мэндийн байгууллагуудын дунд 9 дүгээр сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл 2 сарын хугацаатай зарласугай.
- Болзолт уралдааны зорилго, хамрах хүрээ, хугацаа, ерөнхий шаардлага, дүгнэх, урамшуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, болзолт уралдааныг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар, шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Эрүүл мэндийн яаманд Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт дүүргийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв, Аймгийн эрүүл мэндийн газарт аймгийн нэгдсэн эмнэлэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв болзолт уралдааны дагуу хийсэн ажлаа 11 дүгээр сарын 11-ний дотор тус тус ирүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.
- Эхний 3 байранд шалгарсан материалыг 11 дүгээр сарын 18-ны дотор Эрүүл мэндийн яаманд ирүүлэхийг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
- Болзолт уралдаанд шаардагдах 13 500 000 (Арван гурван сая таван зуун мянган төгрөг) сая төгрөгийг Эрүүл мэндийн сайдын багцын зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т, болзолт уралдааныг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, уралдааны нэгдсэн дунг 11 дүгээр сарын 25-ны дотор шалгаруулж, ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Энхболд/-т, болзолт уралдааны явцад хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080114



Эрүүл мэндийн сайдын 2016 оны
09 сарын 01 өдрийн 11 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

“Шилдэг ариун цэврийн байгууламж” болзолт уралдааны шалгуур үзүүлэлт, зарлах, дүгнэх, урамшуулах ажлын удирдамж

Зорилго: Жил бүрийн 11 дүгээр сарын 19-нд “Дэлхийн 00-ийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд “Стандартын шаардлага хангасан төвлөрсөн болон төвлөрсөн бус ариутгах татуургын системийн тоог нэмэгдүүлэх, ариун цэврийн байгууламжийг нийтэд ээлтэй болгох, шинэ технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх”

Хамрах хүрээ:

- Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа эмнэлгүүд;
- Θрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд;
- Θрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүрээнд зохион байгуулагдана.

Хэрэгжүүлэх хугацаа: 2016 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл 2 сарын хугацаанд зохион байгуулагдана.

Болзолт уралдаанд тавигдах ерөнхий шаардлага:

Уралдааныг энгийн нүхэн жорлон болон төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдсон, хэсгийн цэвэрлэх байгууламжтай ариун цэврийн байгууламжийг тус тусад нь дүгнэнэ.

Ариун цэврийн байгууламжийн дараах 3 төрлийг шалгаруулж дүгнэнэ.Үүнд:

- a/ Төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдсон тохиолдолд:
- Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6392:2013 стандартын 4.2.13-4.2.15 болон 6.1, 6.3-6.5 заалтыг хангах

- b/ Хэсгийн цэвэрлэх байгууламжтай тохиолдолд:

- Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6392:2013 стандартын 4.2.13-4.2.15 болон 6.1-6.5 заалтыг хангах

- v/ Энгийн нүхэн жорлонтой тохиолдолд:

- Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2015 стандартын 6.1-6.7.6 болон 7 дугаар заалтыг хангах

Болзолт уралдааныг дүгнэх:

Ерөнхий шаардлагад заасан стандартуудын заалт тус бүрийг 1 оноогоор, шинэ технологи нэвтрүүлсэн тохиолдолд 10 оноогоор тус тус үнэлнэ.

Болзолт уралдааныг дүгнэх шалгуур үзүүлэлт

ҮЗҮҮЛЭЛТ		ШАЛГУУР	ОНОО
Төвлөрсөн татуургын холбогдсон тохиолдолд:	ариутгах системд	1. Арин цэврийн өрөөний хаалга нь гадагшаа онгойдог бол 2. 10 эрэгтэй үйлчлүүлэгчид 1 сууртууртай бол 3. 8 эмэгтэй үйлчлүүлэгчид 1 сууртууртай бол 4. Эмч, эмнэлгийн ажилтнуудын ариун цэврийн өрөө тусдаа бол 5. Мэдрэгчтэй гарын угаалтууртай бол 6. Халдвартын ба сүрьеэгийн эмнэлгийн ажилчдад 10 хүн тутамд нэг шүршүүртэй бол 7. Бусад эмнэлгийн 15 ажилчдад 1-ээс багагүй шүршүүр 40 үйлчлүүлэгчдэд 1-ээс доошгүй шүршүүртэй бол 8. Халдвартын эмнэлгийн бохир усыг урьдчилан халдвартгүйжүүлэлт хийж ариутгах татуургын төвлөрсөн системд нийлүүлсэн бол 9. Бохир ус цэвэрлэх байгууламжаас гарах ус нь холбогдох стандартад заасан шаардлагыг хангасан бол 10. Хүнд өвчтөн, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, өндөр настай хүмүүст бие засах газар нь хэрэглэхэд хялбар, гэмтэх, бэртэхээс хамгаалсан, тохирсон хэмжээ, загвартай тоноглогдсон бол 11. Шинэ технологи нэвтрүүлсэн бол	1 1 1 1 1 1 1 1 1 1 10
• Тийм • Хэрэгжилтийн хувь			20
Хэсгийн цэвэрлэх байгууламжтай тохиолдолд:		1. Арин цэврийн өрөөний хаалга нь гадагшаа онгойдог бол 2. 10 эрэгтэй үйлчлүүлэгчид 1 сууртууртай бол 3. 8 эмэгтэй үйлчлүүлэгчид 1 сууртууртай бол 4. Эмч, эмнэлгийн ажилтнуудын ариун цэврийн өрөө тусдаа бол 5. Мэдрэгчтэй гарын угаалтууртай бол 6. Халдвартын ба сүрьеэгийн эмнэлгийн ажилчдад 10 хүн тутамд нэг шүршүүртэй бол 7. Бусад эмнэлгийн 15 ажилчдад 1-ээс багагүй шүршүүр 40 үйлчлүүлэгчдэд 1-ээс доошгүй шүршүүртэй бол 8. Цооногт цуглуулсан бохир усыг халдвартгүйжүүлсний дараа зориулалтын тээврийн хэрэгслэлээр тээвэрлэж тогтоосон цэгт зайлуулдаг бол 9. Халдвартын эмнэлгийн бохир усыг урьдчилан халдвартгүйжүүлэлт хийж ариутгах татуургын төвлөрсөн системд нийлүүлсэн бол 10. Бохир ус цэвэрлэх байгууламжаас гарах ус нь	1 1 1 1 1 1 1 1 1 1 1
Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6392:2013 стандартын 4.2.13-4.2.15 болон 6.1-6.5 заалтыг хангах			

	хамгаалсан зориулалтын материалыаар өнгөлсөн бол Бүхээг: 6	1
	<ul style="list-style-type: none"> • Бүхээгийн хана, дээвэр, тэдгээрийн уулзвар завсаргүй, хаалга нь бүрэн онгойж хаагддаг, цэвэр, өнгө үзэмжтэй бол • Бүхээгийн хаалган тал өндөр, ар тал нам, хажуу талууд ижил өндөртэй бол • Бүхээгийн хэмжээ: <ul style="list-style-type: none"> ◦ Том хүний жорлон: <ul style="list-style-type: none"> Нүүрэн талын өндөр-2400 мм Ар талын өндөр-2100мм Хажуу талын өндөр-1200 ◦ Хүүхдийн жорлон: <ul style="list-style-type: none"> Нүүрэн талын өндөр-1600 мм Ар талын өндөр-1400мм Хажуу талын өндөр-900 ◦ Хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настны жорлон: <ul style="list-style-type: none"> Нүүрэн талын өндөр-1600 мм Ар талын өндөр-1400мм 	<ul style="list-style-type: none"> 1 1 1
	<ul style="list-style-type: none"> • Жорлонгийн хаалга нарны гэрлийн эсрэг талруу харсан, хаалганы дээд талд 400мм урт, 200мм өргөн цонхтой бол • Хаалга нь гадна, дотор талдаа түгжээтэй, гэрэлтуулэгтэй, хаалганы дээр ялаа, шавьж орохоос хамгаалсан тор бүхий цонхтой бол • Бүхээг дотор ариун цэврийн цаас, өлгүүр, тагтай хогийн сав, цэвэрлэгээний тоноглол, хэрэгсэлтэй бол 	<ul style="list-style-type: none"> 1 1 1
	Хаяавч:1	
	<ul style="list-style-type: none"> • Жорлонд цас, борооны ус орох, ялааны авгалдай хөрсөөр нэвтэрч гарахаас хамгаалсан бүхээгний эргэн тойронд 500мм-ийн зайнд бетон зуурмаг, чулуу, тоосго, хайрга зэрэг материалыаар жорлонгийн суурийг нүхний амсартай зай завсаргүй холбосон 100 мм-ийн зузаан, жорлонгийн хананаас гадагш налуу хаяавчтай бол 	1
	Агааржуулалтын хоолой: 1	
	<ul style="list-style-type: none"> • Салхивчны хоолойн өндөр бүхээгийн арын хананы өндрөөс 200 мм-ээс багагүй өндөр, голч 200 мм бол <p>Өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан жорлон: 6</p> <ul style="list-style-type: none"> • Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бол тэргэнцэртэй хүн багтахуйц, бүхээгийн өргөн, урт 1.65м x 1.8 м-ээс багагүй, суурин болон зөөврийн суултуур байрлуулсан бол • Хаалганы өргөн нь 1.0 м-ээс багагүй байх ба зориулалтын бариултай бол • Тэргэнцэртэй хүнд шаардлагатай үед тусlamж 	<ul style="list-style-type: none"> 1 1 1

	<ul style="list-style-type: none"> дуудах хонх, тоноглолтой бол 	1
	<ul style="list-style-type: none"> Тэргэнцэртэй ижил өндөртэй, зөөлөвч бүхий суултуур, хамгаалалтын бүстэй бол 	1
	<ul style="list-style-type: none"> Тэргэнцэрээс суултуурт шилжин суухад туслах, сууж байхад гар, мөр, нурууг дэмнэх тулгуур суурилуулж тогтоосон бол 	1
	<ul style="list-style-type: none"> Хаалга нь босгогүй, довжкоо налуу бол 	1
	Эрүүл ахуйн шаардлага: 6	
	<ul style="list-style-type: none"> Жорлонгийн бүхээгийг ариутгаж цэвэрлэх боломжтой, ус чийгэнд тэсвэртэй, өвчин үүсгэх мөөгөнцөр, нян бактери, хортон шавьж үржихгүй, гэрлийн тусгалаас хамгаалагдсан материалаар доторлосон бол 	1
	<ul style="list-style-type: none"> Жорлонгийн бүхээг дотор ариутгал цэвэрлэгээний зөвшөөрөгдсөн бодис ба хэрэгслэлүүдийг бага насын хүүхдийн гар хүрэхээргүй газарт байрлуулан тавьсан бол 	1
	<ul style="list-style-type: none"> Жорлон, угаадасны нүхний орчинд ялаа шавьж үржих, орогнох боломжийг таслах зорилгоор дулааны улиралд ариутгал, халдвартгүйжүүлэлтэд шинэ технологи, био бэлдмэлийг зохих стандартын дагуу устгал, ариутгал хийдэг бол 	1
	<ul style="list-style-type: none"> Нүхэн жорлон, угаадасны нүхийг үйлчилгээний газраас 15 метрээс багагүй зайд барьсан бол 	1
	<ul style="list-style-type: none"> Бие засах нүх зориулалтын тагтай байх бөгөөд хэт халуун болон шөнийн цагаар таглаж, салхитай өдөр онгорхой байдаг бол 	1
	<ul style="list-style-type: none"> Жорлон, угаадасны нүхний орчинд ялаа шавьж үржих, орогнох боломжийг таслах зорилгоор дулааны улиралд стандартын шаардлага хангасан зориулалтын бодис хэрэглэн 7 хоног тутамд устгал хийдэг бол 	1
	Шинэ технологи нэвтрүүлсэн бол	10
	<ul style="list-style-type: none"> Тийм Хэрэгжилтийн хувь 	44

Болзолт уралдааны урамшуулал:

Болзолт уралдаанд шалгарсан 3 байр буюу 9 эрүүл мэндийн байгууллагад “Өргөмжлөл”, “Мөнгөн шагнал” болон уг байгууллагуудыг төлөөлүүлж 12 дугаар сарын 1-3-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулах “Хүйтэн уур амьсгалтай орны ариун цэврийн байгууламж” сэдэвт олон улсын симпозиумд оролцуулна.

Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгүүд:

- 1 дүгээр байр -1
- 2 дугаар байр -1
- 3 дугаар байр -1

Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд:

- 1 дүгээр байр -1
- 2 дугаар байр -1
- 3 дугаар байр -1

Өрхийн эрүүл мэндийн төвүүд:

- 1 дүгээр байр -1
- 2 дугаар байр -1
- 3 дугаар байр -1

Жич: Ариун цэврийн байгууламжийн стандарт болон түүнийг барих, ашиглах, үйлчилгээтэй холбоотой дараах материалыг ашиглана:
(<http://www.mohs.mn/web/index.php/56/item/1137>)

- Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6392:2013
- Нүхэн жорлон, угаадасны нүх.Техникийн шаардлага MNS 5924:2015 стандарт
- Брошур 3
- Постер 2



Эрүүл мэндийн сайдын 2016 оны
Одсарын 04.09 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

**“Шилдэг ариун цэврийн байгууламж” болзолт уралдааны шалгуур үзүүлэлт,
зарлах, дүгнэх, урамшуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн дарга: Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга

Гишүүд: Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын
дарга

Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн Орчны эрүүл мэнд,
химийн бодисын аюулгүй байдлын бодлогын
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Орчны эрүүл
мэнд, хор судлалын төвийн мэргэжилтэн



Эрүүл мэндийн сайдын 2016 оны
09.. сарын 08.. өдрийн 14:00 дугаар
тушаалын 3 дугаар хавсралт

**“Шилдэг ариун цэврийн байгууламж”
болзолт уралдаанд шаардагдах төсөв**

№	Урамшуулах байгууллагын нэрс	Байгууллагын тоо	Урамшууллын хэмжээ (сая/төг)
1.	Тусгай мэргэжлийн төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгүүд: 1 дүгээр байр - 1 2 дугаар байр - 1 3 дугаар байр - 1	3	2000.000 1500.000 1000.000
2.	Сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд: 1 дүгээр байр - 1 2 дугаар байр - 1 3 дугаар байр - 1	3	2000.000 1500.000 1000.000
3.	Өрхийн эрүүл мэндийн төвүүд: 1 дүгээр байр - 1 2 дугаар байр - 1 3 дугаар байр - 1	3	2000.000 1500.000 1000.000
	Дүн	9	13500.00